

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ:

“ИНТЕРСАЙНС” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц. ӨНГИС

Я. АМАРЖАРГАЛ

“ШИНЭ КОРОНАВИРУСЫЙН ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
НИЙЛҮҮЛЭХ /АМЬСГАЛЫН АППАРАТ”

Дугаар № 63

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн яам” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас
“Интерсайнс” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож
2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх)
байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа,
бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх
харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү
гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 оны дугаар сарын 26-
ны өдрийн 77 дугаар тогтоолын 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн
хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн
34.1.5-дахь хэсгийг тус тус үндэслэн “Шинэ коронавирусын халдварын үед эрүүл
мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж
нийлүүлэх /амьсгалын аппарат” –ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн
саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл
болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 1,396,000,000₮ /Нэг тэрбум гурван зуун
ерэн зургаан сая/ төгрөгөөр Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд
санхүүжих дүн 1,396,000,000₮ /Нэг тэрбум гурван зуун ерэн зургаан сая/ төгрөгөөр
барааг хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд
шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж
баталгаажсанаас хойш 8 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
1	1	2	3	4
1	Амьсгалын аппарат	БНХАУ-лс Beijing Aeolimed Co., Ltd	VG70	40

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
Төндөрийн баталгаа;
Төндөр ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/
Засгийн газрын тогтоол

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн яамны
Хуулийн хэлтсийн дарга

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүмцэтгэгч

Т.Бямбасүрэн
ЭМЯ-ны төсвийн ерөнхий
Нягтлан бодогч

Х.Отгонзул
Хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Интерсайнс" ХХК –ийн
Төсөл, технологийн албаны дарга

Санхүүгийн менежер
Н.Эрдэнэсант - 2



Б.Заяа

Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн
газрын VIII байр, 1 давхар 106 тоот
өрөө Улаанбаатар-48, Олимпын
гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: Баянзүрх дүүрэг, 3-р хороо,
12 хороолол, 4б-р байр, 2 давхар
Утас: 70158002, 70158003
И-мэйл: info@interscience.mn
Дансны дугаар: 404189213
Худалдаа, хөгжлийн банк